



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 5. дугаар
сарын 4. өдөр

Дугаар А/105

Улаанбаатар
 хот

Журам батлах тухай

1. Нийслэл, дүүргүүдийн Засаг дарга нарт харьялагдах улсын тийлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хувьцаат компаниуд, төсөвт байгууллагуудад төрийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллахыг холбогдох байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн биелалтэнд хяналт тавьж ажиллахыг Хянан байцаах хэлтэс /н.Цэрэндулам/-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БЕЛӨЛ УЛААНБААТАР ХО-
ТЫН ЗАХИРАГЧ

Ц.БААСАНЖАВ

Ц.БААСАНЖАВ

Нийслэлийн засаг даргын 1995
оны .5-р сарын .4. ны өдрийн
тоот захирамжийн хавсралт

УХБН 11

ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Нийслэл болон дүүргүүдийн засаг даргад харьялагддаг улсын үйлдвэрийн газар, төрийн өмч оролцсон хувьцаат компани, төсөвт байгууллагаудад төрийн өмчийн төлөөлөлийг Монгол Улсын хуулийн хүрээнд хэрэгжүүлэхэд энэ журмыг мөрдлөгө болгоно.

2. Төрийн өмчийн төлөөлөлийн үүргийг гүйцэтгэх ойлголтын хүрээнд улсын үйлдвэрийн газар, төрийн өмч оролцсон хувьцаат компани, төсөвт байгууллага тусгай зориулалтын сан, төсвийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилт, Нийслэл, дүүргийн Засаг даргын мэдлийн орон байр, барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, газар, байгалийн баялаг (цаашид төрийн өмч гэх) зэрэг төрийн өмчийн бүхий л хэлбэрийг ашиглах, эзэмших, захиран зарцуу-лахтай холбогдсон өмчийн харилцаа, хариуцлагыг Монгол Улсын хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамааруулна.

3. Төрийн өмчийн төлөөлөлийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад эрх зүйн баримт бичгүүд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тогтоол захирамжууд үндэслэл нь болно.

4. Нийслэл, дүүргийн засаг даргад харьялагдах төрийн өмчийн аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудад, (цаашид харьяа байгууллагууд гэх) өмчийн төлөөлөлийг хэрэгжүүлэхэд нийслэл, дүүргийн засаг даргын Тамгын газар, Хотын захирагчийн албан алба, засаг даргын дэргэдэх удирдах газрууд нь (цаашид мэргэжлийн албад гэх) энэ журамд заасан үүргийг хүлээж ажиллана.

Хоёр. МЭРГЭЖЛИЙН АЛБАДЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

а. Нийслэл, дүүргийн засаг даргын тамгын газрын засаг захиргааны хэлтэс, хотын захирагчийн албан алба

1. Тус тусын харьяа байгууллагууд, удирдах газруудын албан тайланг жил тутамд хамт олны өмнө тавиулж, үнэлэлт дүгнэлт өгүүлэх шаардлагатай бол Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлж хамгаалуулж байх.

2. Тус тусын харьяа байгууллагын удирдлагыг томилох, цалингийн хэмжээг тогтоох талаар бусад албадын болон салбарын удирдах газрууд болон Өмчийн газрын санал дүгнэлтийг үндэслэж асуудал боловсруулан Засаг даргад танилцуулж шийдвэр гаргуулах буюу шийдвэрлэх

2.

3. Дээрхи байгууллагуудын удирдлагуудтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулан биелэлтэнд нь хяналт тавих.

б. Нийслэл, дүүргийн засаг даргын Тамгын газрын
Эдийн засаг, нийгмийн бодлогын хэлтэс

1. Харьяа байгууллагуудын эдийн засаг, технологийн бодлого, хэтийн төлөв, үндсэн чиглэлийг тодорхойлох

2. Дотоод төлөвлөлтийн системийг бий болгож, Үндэсний Хөгжлийн газраас баталсан арга зүй, төлөвлөгөөний нийтлэг үзүүлэлт, үлгэрчилсэн маягтыг мөрдүүлэх

3. Жил бүрийн төлөвлөлт эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг хянан баталж түүний биелэлтэнд эдийн засгийн дүн шинжилгээг байгууллага бүрээр нь хийлгэж, дүгнэлт өгөх, цаашид үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэхтэй холбогдсон зөвлөмж өгч ажиллах.

4. Үйлдвэрийн газрын болон, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын эдийн засгийн төлөвлөлт, үр дүн, ашгийн хуваарилалттай холбогдолтой асуудлыг хянан үзэж албан ёсны дүгнэлт саналаа гаргаж өгөх

5. Үйлдвэрийн удидлагыг сонгох, томилох, тэдгээрийн тайланг хэлэлцэхтэй холбогдсон асуудлаар санал дүгнэлт гаргаж өгөх.

6. Байгууллагуудын тухайн жилд шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний санхүүжилтийн асуудлыг Санхүүгийн хэлтэс, салбарын удирдах газруудтай хамтран хянан үзэж батлах.

7. Харьяа байгууллагуудын хүчин чадлын бүрэн дүүрэн ашиглалт, төрийн өмчийн өгөөж, ашигт ажиллагааг дээшлүүлэх бодлого чиглэл боловсруулан, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллах.

в. Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын
Санхүүгийн хэлтэс

1. Харьяа байгууллагын захиргааны аппаратын зохион байвалт бүтцийг салбарын удирдах газруудтай хамтран авч үзэж цалингийн сан, шагнал урамшуулалын болон бусад арга хэнжээний сан удирдлагын зардлыг хянаж батлах

2. Харьяа байгууллагуудын захирал, эрх баригчдын өмч хөрөнгө захираан зарцуулах эрх хэмжээг тогтоож өгөх.

3. Харьяа байгууллагуудын тайлан тэнцлийг гаргуулан авч удирдах газруудаар дамжуулж тайлангийн жилийн үйл ажиллагаанд нь үнэлэлт өгөх.

4. Санхүүгийн баримтын шалгалт хийж зөрчил догоолдлыг арилгуулах

3.

5. Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх бүртгэл маягтын жагсаалтыг гарган өгч мөрдөлтөнд нь хяналт тавих

6. Төсөвт байгууллагын төсвийн төлөвлөлтийг хянан батлаж санхүүжүүлэх, түүний зарцуулалтанд хяналт тавих.

7. Байгууллагуудад өгч буй хөрөнгө оруулалт, түүний ашиглалт зарцуулалтанд хяналт тавих.

г. Нийслэлийн засаг даргын дэргэдэх газрууд

1. Өөрийн хариуцсан салбарын хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаагаа явуулж буй байдалд төрийн байгууллагын хяналт тавьж үйл ажиллагааг зохицуулах

2. Харьяа байгууллагуудын үйлдвэрлэл, эдийн засгийн харилцаа, техник технологийн шинэчлэлт, хөгжлийн хэтийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн удирдлагаар хангаж хэрэгжилтэнд нь хяналт тавина.

3. Хариуцсан салбарынхаа төсөвт байгууллагуудын даргыг томилох, түүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг харьяалагдах дүүргийн засаг даргын саналыг авсаны үндсэн дээр шууд хариуцан гүйцэтгэнэ.

ГУРАВ. Өмчийн газрын гүйцэтгэх үүрэг

1. УУГ, төрийн өмчтэй компаниудын эрх баригчийг томилох асуудлыг мэргэжлийн албадын саналыг авсаны үндсэн дээр боловсруулж Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Засаг захиргааны хэлтэс, хотын захирагчийн ажлын албатай хамтран Нийслэлийн Засаг даргад танилцуулан шийдвэрлүүлэх

2. Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компаний Т.У.З, Хяналтын зөвлөлтэй төрийг төлөөлж байгуулах гэрээний төслийг боловсруулж мэргэжлийн албадын санал дүгнэлтийг авч тусган гэрээ байгуулах ажлыг Нийслэл, Дүүргүүдийн Засаг захиргааны хэлтэс, Хотын захирагчийн ажлын албатай хамтран зохион байгуулах.

3. Аж ахуйн нэгжийн, захирал дарга нар Т.У.Зөвлөл, Хяналтын зөвлөлтэй төрийг төлөөлж байгуулах гэрээний төслийг боловсруулж мэргэжлийн албадын санал дүгнэлтийг авч тусган гэрээ байгуулах ажлыг Нийслэл, Дүүргүүдийн Засаг захиргааны хэлтэс, Хотын захирагчийн ажлын албатай хамтран зохион байгуулах.

4. Нийслэл, Дүүргүүдийн засаг даргад харьяалагдах төсөвт байгууллагуудад төрийн өмчийн эзэмшлийн гэрээгээр төрийн өмчийн төлөөлөлийг хэрэгжүүлэн ажиллана.

5. Аж ахуйн нэгж байгууллагуудын дүрэм, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтөнд төрийн өмчийг төлөөлж санал өгех.

6. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоох татаан буулгах, аж ахуйн хэлбэрийг өөрчлөх, дампууруулахад

төрийн өмчийг төлөөлсөн эрхтэйгээр оролцож, эдгээр аж ахуйн нэгжийн өмчийн маргааны асуудлаар шүүхийн байгууллагад төрийн өмнөөс нэхэмжлэл гаргана.

7. Аж ахуйн нэгж байгууллагын өмчийг хувьчлах, бусдад шилжүүлэх, данснаас хасах, худалдах, дахин үнэлэх тохиолдолд төрийн өмнөөс хууль тогтоомжийн заалт зөрчигдэж байгаа эсэхэд хяналт тавиж, эсэргүүцэл хориг саад тавих.

8. Аж ахуйн нэгж байгууллагын удирдлагын гэрээний биелэлтийг дараа оны 1-р улиралд багтаан дүгнэж, мэргэжлийн албадын санал авч шаардлагатай тохиолдолд Нийслэл, Дүүргүүдийн Засаг захиргааны хэлтэс, Захиргчийн ажлын албатай хамтран засаг даргын Зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлнэ.

9. Төрийн өмчийн оролцоотой компаниудийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, хуралд төрийг төлөөлж оролцох, хэлэлцэх асуудлаар санал өгөх ажлыг хариуцах.

10. Аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчийн бүтцийг боловсронгуй болгох, түүнийг эзэмших, ашиглах арга хэлбэрийг өөрчлөх, сайжруулах талаар санал дүгнэлт гаргаж Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулан хэрэгжилтэнд нь хяналт тавих.

11. Харьяа У.У.Газрууд, төрийн өмчтэй компаниудын төлөвлөгөөний болон тайлангийн үзүүлэлтүүдийг тогтоосон хугацаанд нь гаргуулж, нэгтгэн хянах, холбогдох мэргэжлийн албадуудаар баталгаажуулах ажлыг хариуцаж зохион байгуулах.

12. У.У.Газрууд, төрийн өмчтэй компаний дүрмийн сангийн бүртгэл, төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгийн бүртгэлийг бүртгэж, өөрчлөлт гарсан, хөренгө оруулалт хийгдсэн тохиолдолд холбогдох материалыг бүрдүүлж хөдөлгөөн хийж Татварын болон санхүүгийн албанад мэдээлж байна.

13. Аж ахуйн нэгж байгууллагуудын үндсэн хөрөнгийг данснаас хасах, худалдах, хувьчлах, бусдад шилжүүлэх үнэлэх асуудлыг боловсруулж эрх бүхий байгууллагад оруулж шийдвэрлүүлэх .

14. Нийслэлийн Засаг даргад харьяалагдах төрийн өмчийн бүх үндсэн хөрөнгийн техникийн бичиг баримтыг бүрдүүлэх

15. Төрийн өмчийн орон байшин, барилга, байгууламж, машин тоног төхөөрөмжийн эзэмшилт, ашиглалтанд хяналт тавьж, эзэмшлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулан, ажлын байр, үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар санхүүгийн хэлтэс, бусад газруудтай хамтран асуудал боловсруулж шийдвэрлүүлэх, буруутай аж ахуйн нэгж, байгууллага, хүмүүст зохих хариуцлага хүлээлгэх.

5.

16. Төрийн өмчийн орон байр, барилга байгууламж, машин, тоног төхөөрөмжийг түрээсээр эзэмшигчидтэй түрээсийн гэрээ байгуулан ажиллаж, түрээсийн төлбөрийг хугацаанд нь төвлөрүүлж, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллах.

17. Түрээсийн төлбөрөөс үндсэн хөрөнгийн их засвар сэргээн босголтын сан байгуулж, төрийн өмчийн барилга, байгууламж, машин, тоног төхөөрөмжийн их засвар сэргээн босголтын ажлыг санхүүжүүлж хариуцан гүйцэтгэнэ.

18. Газар эзэмшүүлэх болон, ашиглуулах тухай эрх бүхий байгууллагаас олгосон эрх зүйн баталгааг үндэслэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших, ашиглах тухай гэрээг байгуулж улсын бүртгэлд бүртгэх, түрээсийн төлбөр тооцоо хийх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

19. Нийслэлийн нутаг дэвсгэрт ус, түгээмэл тархацтай эрдэс түүхий эд, байгалийн дагалдах баялаг зэргийг олборлож ашигласнаас авах төлбөр тооцоог тогтоох, хураан барагдуулж хотын төсөвт төвлөрүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

20. Дээрхи хоёр төрлийн хөрөнгөнөөс тусгайлсан сан байгуулж хөрөнгө оруулалтын эх үүсвэр болгосон тохиолдолд уг сангаас олгосон хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавина.